



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/9/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дархан-Уул аймаг

2025 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр

Утас:70373089, 99023682

Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Утас:99023682

Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас:99377479

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК

Захирал: Б.Жаргалсайхан

Утас:99862066

Цахим хаяг:peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ хвдалдан авах



ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ТҮМЭНЦОГТ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 133

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус сан нь тайлант онд 129,776.8 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч 58,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглаж боломжтой 750.0 мянган төгрөгийн программ хангамжийн үнийг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд тодруулж, толилуулсан байна.

4525020221

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Орхон сумын хоршоо хөгжүүлэх сан нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг мөрдөн ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	264,921,655.12	270,759,260.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	77,276,764.70	84,895,878.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	77,276,764.70	84,895,878.70
3121	Төгрөг	77,276,764.70	84,895,878.70
31211	Төрийн сангийн харилцах	77,276,764.70	84,895,878.70
33	АВЛАГА	185,048,399.42	183,266,890.73
33400	Зээлийн хүүгийн авлага	9,080,980.01	8,986,492.32
335	Бусад авлага	175,967,419.41	174,280,398.41
3351	Байгууллагаас авах авлага	400,000.00	400,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	175,567,419.41	173,880,398.41
35	БАРАА МАТЕРИАЛ	2,596,491.00	2,596,491.00
354	Хангамжийн материал	2,596,491.00	2,596,491.00
35420	Аж ахуйн материал	2,596,491.00	2,596,491.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	750,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	750,000.00
393	Биет бус хөрөнгө	-	750,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	264,921,655.12	271,509,260.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	94,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	94,000.00
413	Өглөг	-	94,000.00
4136	Бусад өглөг	-	94,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	94,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	264,921,655.12	271,415,260.43
51	Засгийн газрын хувь оролцоо	264,921,655.12	271,415,260.43
512	Хуримтлагдсан үр дүн	264,921,655.12	271,415,260.43
51210	Өмнөх үеийн үр дүн	264,921,655.12	264,921,655.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,493,605.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	264,921,655.12	271,509,260.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,092,097.50	7,990,405.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,092,097.50	7,990,405.31
120	Нийтлэг татварын бус орлого	7,092,097.50	7,990,405.31
120002	Хүүгийн орлого	7,092,097.50	7,240,405.31
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		750,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,829,600.00	1,496,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,829,600.00	1,496,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,829,600.00	1,496,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,679,600.00	1,496,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,679,600.00	1,496,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	5,262,497.50	6,493,605.31
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	5,262,497.50	6,493,605.31

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	59,440,762.01	67,021,914.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,440,762.01	67,021,914.00
120	Нийтлэг татварын бус орлого	59,440,762.01	67,021,914.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,440,762.01	67,021,914.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,440,762.01	67,021,914.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,679,600.00	1,402,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,679,600.00	1,402,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,679,600.00	1,402,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,679,600.00	1,402,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,679,600.00	1,402,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	57,761,162.01	65,619,114.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	58,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	0.00	58,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	(58,000,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	57,761,162.01	7,619,144.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,515,602.69	77,276,764.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,276,764.70	84,895,878.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			259,659,157.62		259,659,157.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	259,659,157.62	-	259,659,157.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C07	Тайлант үеийн үр дүн			5,262,497.50		5,262,497.50
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	264,921,655.12	-	264,921,655.12
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	264,921,655.12	-	264,921,655.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	264,921,655.12	-	264,921,655.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			6,493,605.31		6,493,605.31
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	271,415,260.43	-	271,415,260.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	132,276,800.00	59,402,800.00	(72,874,000.00)	44.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,500,000.00	1,402,800.00	(1,097,200.00)	56.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,500,000.00	1,402,800.00	(1,097,200.00)	56.11
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00	1,402,800.00	(1,097,200.00)	56.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	1,402,800.00	(1,097,200.00)	56.11
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	129,776,800.00	58,000,000.00	(71,776,800.00)	44.69
230001	Эргэж төлөгдөх зээл	129,776,800.00	58,000,000.00	(71,776,800.00)	44.69
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	132,276,800.00	67,021,914.00	(65,254,886.00)	50.67
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	132,276,800.00	67,021,914.00	(65,254,886.00)	50.67
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	132,276,800.00	67,021,914.00	(65,254,886.00)	50.67
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-	-	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	77,276,764.70	77,276,764.70	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	84,895,878.70	84,895,878.70	0.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй гараагүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын хоршоо хөгжүүлэх сан нь сум орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг бий болгох, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны тоог нэмэгдүүлэхэд оршино гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэн ажилладаг. Сангийн зээлээр зоорийн аж ахуй, хүлэмжийн аж ахуй, туслах аж ахуйг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Орхон сумын хоршоо хөгжүүлэх сан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон хэмжээний өөрчилт ороогүй, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дугаар тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-г баримтлан ажиллаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоо хөгжүүлэх сан нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,587.6 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	77,276.8	84,895.9	7,619.1
Авлага	185,048.4	183,266.9	(1,781.5)
Бараа материал	2,596.5	2,596.5	-
Үндсэн хөрөнгө	-	750.0	750.0
Нийт хөрөнгө	264,921.7	271,509.3	6,587.6
Богино хугацаат өр төлбөр	-	94.0	94.0
Эздийн өмчийн дүн	264,921.7	271,415.3	6,493.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	264,921.7	271,509.3	6,587.6

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 84,895.9 мянган төгрөг болж өмнөх оноос 7,619.1 мянган төгрөгөөр өссөн, 67,253.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү төлөгдөж, 58,000.0 мянган төгрөгийн зээл олгосонтой холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 183,266.9 мянган төгрөг болж өмнөх оноос 1,781.5 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Тайлант онд бараа материалын дансанд 220.8 мянган төгрөгийн бичиг хэрэгийн материал худалдан авч, зарцуулснаар үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсвийн санхүүжилт төсвийн гүйцэтгэл гараагүй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндсэн зээл төлөлтийн орлогоос 129,776.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжын орлогоос 2,500.0 мянган төгрөг, нийт 132,276.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг хэвээр баталсан байна.

Төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь тайлант хугацааны төсвийн төсөлтэй уялдаж, Төсвийн тухай хуульд заасан төсвийн шаардлагад нийцсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр төлбөр хураамжын орлого авлагаас 7,334.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 59,687.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, эргэж төлөгдөх зээлд 58,000.0 мянган төгрөг олгон, урсгал үйл ажиллагааны зардал 1,402.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 84,895.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
	Код	Нэр			Зөрүү	Хувь
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,500.0	7,334.9	4,834.9	293.4
2	83111	Сум хөгжүүлэх	129,776.8	59,687.0	(70,089.8)	46.0
Нийт дүн			132,276.80	67,021.91	(65,254.89)	50.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсвийн тайлан байхгүй болно.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй болно.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Орхон сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/14 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан дахь цэвэр хөрөнгө болон өмчийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан дахь цэвэр хөрөнгө өмчийн дүнгээс 264,921.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5,298.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд алдаа зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	160.00	1	160.00	100
Нийт дүн	1	160.00	1	160.00	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 750.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 750.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулсан..

2024 оны санхүүгийн тайланд хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоосон 750.0 мянган төгрөгийн программ хангамжийг бүртгээгүй нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар

баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10 дугаар бүлэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулав.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Программ хангамжийг орлого авалгүй.	1	750.0	1	750.0			1	750.0				
	1	750.0	1	750.0	0	0	1	750.0	0	0	0	0